

“ТӨГСӨГЧДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУДАЛГАА”
ТЕХНИКИЙН САНАЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

1. Ерөнхий мэдээлэл “Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа”-ны мэдээлэл цуглуулах, мэдээллийн бааз бүрдүүлэх ажлуудыг захиалагчийн мэргэжил, арга зүйн удирдлага, хяналт дор гүйцэтгэх

2. Зөвлөхийг сонгох ажиллагаа Зөвлөх үйлчилгээний зарлалыг 2018 оны 03 сарын 16-нд “Өнөөдөр сонин”-ы №049 дугаарт нийтлүүлсэн ба 7 байгууллага оролцох хүсэлт, мэдүүлэг ирүүлсэн. Санал ирүүлсэн б айгууллагуудаас Үнэлгээний хорооны 2018 оны 03 сарын 29-ны өдрийн хурлаар доорх шаардлагыг хангасан 4 байгууллагыг хураангуй жагсаалтад оруулан тендерийн урилга хүргүүлсэн. Шаардлага:

1. Судалгаа, шинжилгээний ажлын чиглэлээр 5-аас доошгүй жил үйл ажиллагаа явуулсан туршлагатай
2. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээтэй
3. Хөдөлмөрийн харилцааны асуудлын хүрээнд судалгааны ажил хийсэн
4. Мэдээлэл цуглуулах хангалттай туршлагатай, ажиллах хүний нөөцтэй
5. Судалгааны багийн ахлах, голлох мэргэжилтнүүд нь хөдөлмөрийн харилцааны асуудлыг ойлгох, оношлох мэдлэг, туршлагатай
6. Эдийн засаг, нийгмийн шинжлэх ухааны чиглэлээр мэргэшсэн байх

Урилга хүргүүлсэн 4 байгууллага тендерээ ирүүлсэн.

3. Техникийн саналын үнэлгээ “Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа”-ны зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтад “Стратеги академи”, “ММСГ” ХХК, “SICA” ХХК, “IRIM” ХХК гэх байгууллагууд нь 2018-05-14 10 цаг 00 минутаас өмнө тус тус материалаа ирүүлсэн. Тендерийг тухайн өдрийн 10 цаг 30 минутаас нээж, тухайн өдрөө техникийн саналын үнэлгээг эхлүүлсэн.

Үнэлгээний хороо Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтын захирлын А/01 дугаар тушаалаар байгуулагдаж үнэлгээнд “Зөвлөх үйлчилгээний тендерийн үнэлгээний заавар”,

“Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагааг зохицуулах журам” баримтлан ажилласан.

ТББ-ийн ТӨХ-ийн 1.1-д зааснаар Чанарын үнэлгээний аргаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 38.3 зүйлд зааснаар техникийн санал нь хамгийн өндөр оноо авсан зөвлөхийн санхүүгийн саналыг нээж, тухайн зөвлөхтэй санхүүгийн болон бусад нөхцөлийг харилцан тохиролцох хэлэлцээр хийх зарчмаар зохион байгуулж явууллаа..

Үнэлгээний хорооны үнэлгээгээр техникийн санал нь хамгийн өндөр оноо авсан “ММСГ” ХХК-тай санхүүгийн санал болон бусад нөхцлийг тохиролцсоны үндсэнд “Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа”-ны мэдээлэл цуглуулалтыг гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах эрх олголоо.